

Мэдээллийн төлбөрийн үнэлгээний жишиг

1.Цагдаагийн байгууллага гэмт хэргийн болон эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн талаарх мэдээллийг авахдаа дор дурдсан мэдээллийн төлбөрийн үнэлгээний жишгийг баримтална:

№	Мэдээллийн төлбөрийн үнэлгээний жишгийн шалгуур	Мөнгөн дүнгийн аргачлал /Тооцооны нэгжээр/
1	нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тогтоосон гэмт хэрэгт	10-500
2	найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тогтоосон гэмт хэрэгт	100-1000
3	арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тогтоосон гэмт хэрэгт	1000-10000
4	арван хоёроос дээш жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тогтоосон гэмт хэрэгт	2000-20000
5	үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, террор үйлдэх гэмт хэрэгт	4-т заасан үнэлгээний дээд хязгаарыг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцож болно.
6	бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан эсхүл их хэмжээний хохиролтой, бусад ээдрээ төвөгтэй гэмт хэрэгт	
7	эрэн сурвалжлагдаж буй түүх, дурсгалын болон бусад хосгүй үнэт зүйлийн талаарх мэдээллийг	

2. Гэмт хэргийн талаарх мэдээллийн ач холбогдлыг харгалзан төлбөрийг энэхүү жишигт нийцүүлэн цагдаагийн төв байгууллага тогтоож болно.

3.Мэдээллийг төлбөртэй авах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийнбайгууллага нь тухайн орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгөөс гаргуулж болно.